



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 11 сарын 20 өдөр

Дугаар 544

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас
балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Геологийн судалгааны төв" төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 22,000,000.00 (хорин хоёр сая) төгрөгийн балансын үнэ, 183,333.33 (нэг зуун наян гурван мянга гурван зуун гучин гурван төгрөг гучин гурван мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан суудлын автомашиныг "Мэдээлэл холбооны сүлжээ" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанид балансаас балансад шилжүүлсүгэй.

2. "Геологийн судалгааны төв" төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Н.Ганболд, "Мэдээлэл холбооны сүлжээ" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн гүйцэтгэх захирал Ч.Золбаяр нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг тус тус даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2019 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ир үүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.


ДАРГА

Ц.НЯМ-ОСОР

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ГАВАА

0002459



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны дугаар сарын 1-ны өдрийн
8/4 дугаар тогтоолын хавсралт

**"ГЕОЛОГИЙН СУДАЛГААНЫ ТӨВ" ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ
"МЭДЭЭЛЭЛ ХОЛБООНЫ СҮЛЖЭЭ" ТӨРИЙН ӨМЧИТ ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИД
БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалт ад орсон он	Хэм жих нэгж	Тоо хэм- жээ	Балансын нийт үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Суудлын автомашин Тоёота Приус-30, УНЯ 34-41	2018	ш	1	22,000,000.00	183,333.33	21,816,666.67
	Нийт дүн				22,000,000.00	183,333.33	21,816,666.67
					(хорин хоёр сая)	(нэг зуун наян гурван мянга гурван зуун гучин гурван төгрөг гучин гурван мөнгө)	(хорин нэгэн сая найман зуун арван зургаан мянга зургаан зуун жаран зургаан төгрөг жаран долоон мөнгө)